



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/104/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхбаатар

Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Аудитор: П.Ариунзаяа

Утас: 261628 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн “Конфиденсе Аудит” ХХК-ийн

Захирал: П.Ариунаа

Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УРГАМАЛ, МАЛЫН ЭРҮҮЛ АХУЙ,
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Э.ЦОГОО ТАНАА

2025.03.17 № 07/1040
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд баригдаж эхэлсэн 6,885,773.4 мянган төгрөгийн өртөгтэй хилийн боомтын хорио цээрийн барилгын суурийн цутгалтын бетон шаардлага хангахгүй болж 2022 онд ажлыг зогсоосон боловч 2024 оны төгсгөлд барилгын ажлыг гүйцээхээр шийдвэрлэж тендер зарласан байгаа нь төсөл зээлийн гэрээнд батлагдсан хугацаанд буюу 2025 оны 11 сард дуусах боломжгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн эргэлтийн хөрөнгөд бүртгэгдсэн Дорноговь аймгийн Замын-үүд болон Сайншанд сумдад баригдсан нийт 4,413,293.4 мянган төгрөгийн өртөгтэй Гаалийн хяналтын лаборатори, Мал эмнэлгийн лаборатори, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар сумдад баригдсан нийт 5,155,225.3 мянган төгрөгийн өртөгтэй Гаалийн хяналтын лаборатори, Мал эмнэлгийн лабораторийн барилгын ажлууд дуусаж, барилга хүлээлцэх шатанд байна.

Бусад асуудал

АХБ-д хүргүүлсэн төслийн 2024 оны үйл ажиллагааны тайланд төслийн хэрэгжилтийг 58.6 хувьтай байна гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,004,743,439.90	19,315,520,679.31
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	319,026,548.18	300,325,182.06
312	Төрийн сангийн нэгдсэн данс /төгрөгөөр/	3,724,526.69	4,817,394.78
312	Төрийн сангийн нэгдсэн данс /гадаад валютаар/	315,302,021.49	295,507,787.28
33	АВЛАГА	5,453,089.99	1,864,363.62
33100	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,453,089.99	1,864,363.62
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	720,000.00	80,000.00
34600	Урьдчилж төлсөн зардал	720,000.00	80,000.00
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	16,679,543,801.73	19,013,251,133.63
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	16,679,543,801.73	19,013,251,133.63
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	55,237,222.00	48,284,870.42
392	Үндсэн хөрөнгө	53,627,222.00	47,134,870.42
393	Биет бус хөрөнгө	1,610,000.00	1,150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,059,980,661.90	19,363,805,549.73
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	12,114,402.68	13,829,616.39
41363	ХХОАТ-ын өглөг	3,554,836.15	5,270,050.00
41364	НДШ-ийн өглөг	8,559,566.53	8,559,566.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	17,047,866,259.23	19,349,975,933.34
512	Хуримтлагдсан үр дүн	17,047,866,259.23	19,349,975,933.34
51210	Өмнөх үеийн үр дүн	15,800,467,768.63	17,042,737,456.60
51220	Тайлант үеийн үр дүн	1,247,398,490.60	2,307,238,476.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	17,059,980,661.90	19,363,805,549.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,557,780,921.79	3,203,383,660.20
120044	Гадаадын тусламжийн санхүүжилт	1,172,039,698.00	3,103,462,900.56
120045	Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт-МУЗГ санхүүжилт	385,741,223.79	99,620,759.64
120009	Тендерийн орлого	-	300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	310,881,365.90	899,510,701.09
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,881,365.90	899,510,701.09
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	171,360,000.00	200,273,774.86
210101	Үндсэн цалин	171,360,000.00	200,273,774.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,400,960.00	21,532,673.20
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	20,400,960.00	21,532,673.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,512,789.98	40,287,226.58
210304	Байрны түрээс	38,512,789.98	40,287,226.58
2104	Хангамж бараа материалын зардал	6,900,190.42	16,735,244.90
210401	Бичиг хэрэг	1,700,182.80	1,104,827.34
210402	Тээвэр шатахуун (зогсоол, сэлбэг хэрэгсэл)	706,952.71	7,717,959.10
210402	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,599,079.41	2,384,502.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	893,975.50	1,493,564.81
210601	Багаж техник хэрэгсэл	-	2,509,185.51
210604	Урсгал засвар	-	1,525,205.86
2107	Томилолтын зардал	1,044,574.22	10,568,211.11
210702	Дотоод томилолт	1,044,574.22	10,568,211.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	48,021,770.41	588,199,990.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр-Зөвлөх үйлчилгээ	19,148,170.00	557,042,671.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,400,000.00	27,360,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,087,170.41	214,048.00
210803	Даатгал	243,540.00	117,612.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	142,890.00	3,381,140.90
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	-	84,518.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,641,080.87	21,913,580.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,767,292.31	6,206,773.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	17,873,788.56	15,706,806.58
3	ҮЙЛ АЖИЛАГААНЫ ҮР ДҮН	1,246,899,555.89	2,303,872,959.11
4	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	498,934.71	3,365,517.63
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	498,934.71	3,365,517.63
6	ҮЙЛ АЖИЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,247,398,490.60	2,307,238,476.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	566,919,528.56
120044	Гадаадын зээлийн санхүүжилт	-	564,879,428.56
120010	Бусад орлого	-	2,040,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	283,103,812.21	408,947,583.32
21	Бараа, үйлчилгээний зардал	283,103,812.21	408,947,583.32
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	171,360,000.00	202,414,757.32
210101	Үндсэн цалин	171,360,000.00	202,414,757.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	20,400,960.00	21,256,653.29
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	20,400,960.00	21,256,653.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,404,445.00	36,843,170.00
210304	Байрны түрээсийн хөлс	34,404,445.00	36,843,170.00
2104	Хангамж бараа материалын зардал	5,398,367.60	11,158,144.80
210401	Бичиг хэргийн материал	1,463,354.00	900,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	6,847,036.36
210402	Шуудан холбооны зардал	3,079,703.60	2,061,042.72
210402	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	855,310.00	1,350,065.72
2106	Эд хогшил урсгал засварын дүн	-	2,683,545.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	1,428,000.00
210604	Урсгал засвар	-	1,255,545.00
2107	Томилолт, зочны зардал	1,617,600.00	9,327,600.00
210702	Дотоод албан томилолт	1,617,600.00	9,327,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	43,592,890.00	119,647,767.10
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,148,170.00	92,160,749.10
210802	Аудитын төлбөр	24,000,000.00	24,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,540.00	214,048.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	129,900.00	3,166,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,329,549.61	5,615,945.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,329,549.61	5,615,945.81
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(283,103,812.21)	157,971,945.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
220001	Барилга байгууламж, их засвар, захиалагчийн хяналт	27,261,289.00	171,284,374.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	8,754,455.00
7	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(27,261,289.00)	(180,038,829.00)
8	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	498,934.67	3,365,517.63
9	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	498,934.67	3,365,517.63
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(309,866,166.54)	(18,701,366.13)
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	628,892,714.74	319,026,548.19
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	319,026,548.19	300,325,182.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	15,800,467,768.63	15,800,467,768.63
Тайлант үеийн үр дүн	1,247,398,490.60	1,247,398,490.60
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	17,047,866,259.23	17,047,866,259.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(5,128,802.63)	(5,128,802.63)
Тайлант үеийн үр дүн	2,307,238,476.74	2,307,238,476.74
2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	19,349,975,933.34	19,349,975,933.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,143,980,000.00	3,127,569,884.32	16,410,115.68	99.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	888,980,000.00	880,902,038.32	8,077,961.68	99.09
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,980,000.00	880,902,038.32	8,077,961.68	99.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,500,000.00	223,671,410.61	5,828,589.39	97.46
210101	Үндсэн цалин	204,000,000.00	202,414,757.32	1,585,242.68	99.22
210201	Ажил олгогчоос төлөх НДШ	25,500,000.00	21,256,653.29	4,243,346.71	83.36
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	37,000,000.00	36,843,170.00	156,830.00	99.58
210304	Байрны түрээс	37,000,000.00	36,843,170.00	156,830.00	99.58
2104	Хангамж, бараа материал	11,330,000.00	11,158,144.80	171,855.20	98.48
210401	Бичиг хэрэг	900,000.00	900,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	6,850,000.00	6,847,036.36	2,963.64	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,080,000.00	2,061,042.72	18,957.28	99.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,350,065.72	149,934.28	90.00
2106	Эд хогшил урсгал засвар	11,800,000.00	11,438,000.00	362,000.00	96.93
210601	Багаж техник хэрэгсэл	10,500,000.00	10,182,455.00	317,545.00	96.98
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,255,545.00	44,455.00	96.58
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	9,327,600.00	172,400.00	98.19
210701	Дотоод албан томилолт	9,500,000.00	9,327,600.00	172,400.00	98.19
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр	583,550,000.00	582,847,767.10	702,232.90	99.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	555,500,000.00	555,360,749.10	139,250.90	99.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,000,000.00	24,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	107,000.00	106,920.00	80.00	99.93
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	174,048.00	25,952.00	87.02
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,000.00	40,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,703,000.00	3,166,050.00	536,950.00	85.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,300,000.00	5,615,945.81	684,054.19	89.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,300,000.00	5,615,945.81	684,054.19	89.14
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,255,000,000.00	2,246,667,846.00	8,332,154.00	99.63
220001	Барилга байгууламж	2,255,000,000.00	2,246,667,846.00	8,332,154.00	99.63
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,143,980,000.00	3,103,462,900.56	40,517,099.44	98.71
120	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГААС	3,143,980,000.00	3,103,462,900.56	40,517,099.44	98.71
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,143,980,000.00	3,103,462,900.56	40,517,099.44	98.71
5	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	319,026,548.18	-	
6	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	300,325,182.06	-	
	АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5		100.0
	Удирдах ажилтан	1	1		100.0
	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зөвлөхөд төлсөн шууд төлбөрийг бүртгээгүй орхигдуулсныг залруулах;	1	171,554.3	1	171,554.3	-	-	1	171,554.3	-	-	-	-
2	Бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэх төлбөрийг зардлаар бүртгэснийг залруулах;	1	21,798.4	-	-	1	21,798.4	1	21,798.4	-	-	-	-
3	Зардлын ангиллыг сольж бүртгэсэн	1	2,581.0	-	-	1	2,581.0	1	2,581.0	-	-	-	-
	Нийт Дүн	3	195,933.7	1	171,554.3	2	24,379.5	3	195,933.7	-	-	-	-